

ГАРЧИГ

| | |
|---|----|
| НЭГ. УУРХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА..... | 3 |
| ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ | 7 |
| ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ..... | 9 |
| ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ | 11 |
| ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ | 13 |
| ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ | 16 |
| ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ..... | 17 |
| НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ..... | 18 |
| ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР | 19 |
| АРАВ. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ | 20 |
| АРВАННЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ | 21 |
| АРВАНХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ..... | 22 |
| ДҮГНЭЛТ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ЗАРЦУУЛСАН НИЙТ ТӨСӨВ..... | 23 |

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

| | |
|--|----|
| Хүснэгт 1. MV-014228 тоот тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд | 3 |
| Хүснэгт 2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн төсөв | 23 |

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

| | |
|--|----|
| Зураг 1. Эрээний нүүрсний уурхайн байршил..... | 4 |
| Зураг 2. Авто пүүний 2 талыг цементлэсэн байдал..... | 7 |
| Зураг 3. Уурхайн кемпэд лед гэрэл суурилуулсан байдал..... | 8 |
| Зураг 4. Уурхайн тосгонд мод тарьж буй байдал..... | 10 |
| Зураг 5. Нөхөн сэргээлт хийж буй байдал..... | 11 |
| Зураг 6. Нөхөн сэргээлт хийсний дараах байдал | 12 |

НЭГ. УУРХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Төслийн ерөнхий мэдээлэл

“Илчит металл” ХХК нь 2005 оны 12-р сарын 08-нд байгуулагдсан ба Булган аймгийн Сайхан сумын нутаг, Эрээний ихэр уул нэртэй газарт орших 65,59 га талбайд MV-014228 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2008 оны 09-р сарын 30-ний өдөр 30 жилийн хугацаагаар авсан байна.

Эрээний нүүрсний орд газар нь засаг захиргааны хувьд Улаанбаатар хотоос баруун зүгт 400 км, Эрдэнэт хотоос баруун зүгт 168 км, Булган аймгаас баруун зүгт 100 км, Булган аймгийн Сайхан сумаас баруун хойд зүгт, ашиглаж дууссан Сайхан овоогийн нүүрсний уурхайгаас зүүн зүгт 11 км тус тус зайтайгаар оршино.


Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Орхон Сэлэнгийн геологи-тектоникийн бүст орших ба Ордын районы гадаргуу нь дов толгодорхуу, хамгийн өндөр цэг нь Сайхан уул бөгөөд далайн түвшнээс дээш 1856 м өндөрт оршдог. Ордын талбай нь газарзүйн байрлалаар Төв монголын төвийн атираат мужийн хойд хэсэгт хамаарагдана. Манай орны Хангай-Хөвсгөлийн уулсын зүүн хэсэг Хангайн нурууны төдийлөн өндөр биш уулс нуруу бүхий, өмнөд хэсгийн үргэлжлэл бөгөөд ерөнхийдөө ойт хээрээс тал хээрт шилжсэн завсрын бүсэд багтдаг.

1:1000000-ны масштабтай планшетын М-48-109 хавтгайд оршино.

“Илчит металл” ХХК-ийн эзэмшдэг MV-014228 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1. MV-014228 тоот тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд

| Цэгийн дугаар | Уртраг | | | Өргөрөг | | |
|---------------|--------|-------|--------|---------|-------|--------|
| | Градус | Минут | Секунд | Градус | Минут | Секунд |
| 1 | 102 | 34 | 40,75 | 48 | 48 | 26,84 |
| 2 | 102 | 34 | 0,74 | 48 | 48 | 26,84 |
| 3 | 102 | 34 | 0,74 | 48 | 48 | 52,83 |
| 4 | 102 | 34 | 40,75 | 48 | 48 | 52,83 |



Зураг 1. Эрээний нүүрсний уурхайн байршил

“Илчит металл” ХХК нь “Эрээний нүүрсний” ордын нөөцийн тооцоонд хийсэн шинжээчдийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн УУХҮЯ, АМГТГ-ын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2020 оны 07-р сарын 06-ний өдрийн хуралдаанаар ХХ-10-18 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан, Нүүрсний ордын нөөцийг 2019 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нь бодитой(В) нөөцийг 342482,34 тн, боломжтой(С) нөөцийг 317019,56 тн, тн-оор, бодитой болон боломжтой(В+С) нөөцийг 659501,9 тн-оор тус тус ашигт малтмалын нөөцийн улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

Төсөл үйлдвэрлэлийн нөөцийг тооцохдоо ашиглалтын үед бохирдол 6%/13,0 мян.тн/, хаягдал 3%/6.3 мян.тн/ байхаар тооцоолон үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэн ил уурхайгаас 21705 мян.тн нүүрс олборлохоор төлөвлөсөн байна.

“Илчит металл” ХХК нь Булган аймгийн Сайхан сумын нутаг, Эрээний ихэр уул нэртэй газарт орших 65,59 га талбайд MV-014228 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2008 оны 09-р сарын 30-ний өдөр 30 жилийн хугацаагаар авсан. Улмаар тус ордыг ил аргаар ашиглах ТЭЗҮ-ийг 2020 оны 07 сарын 06-ны өдөр УУХҮЯ-ы АМГТ-ын ЭБМЗ-ийн ХХ-10-18 дугаар дүгнэлтээр хэлэлцэж батласан.

2020 оны 08 сарын 14-ны өдөр УУХҮЯ-ы АМГТ-ын даргын Н/74 тоот тушаалаар ТЭЗҮ-ийг хүлээн авсан. Мөн ТЭЗҮ-ийг уул уурхайн зураг төслийн “Этолл майнинг” ХХК-иар боловсруулуулан 2021 оны 02 сарын 10-нд АМГТГ-ын ЭБМЗ-ийн Т/21-02-09 дугаар дүгнэлтээр ТЭЗҮ-ийг хэлэлцэж батласан. Эрээний нүүрсний ил уурхайн ТЭЗҮ-ээр жилд дунджаар 45 мян.тн нүүрс олборлон ордын нөөцийг 5 жилийн хугацаанд ашиглахаар тооцсон байна.

2.2. Төслийн хүчин чадал, ажиллах горим

Тус ордын геологийн тогтоц, гидрогеологи, уул-геологи, уул-техникийн нөхцлөөс хамааруулан уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлыг эксковатор-автосамосвалын хослол бүхий тээвэртэй ашиглалтын системээр ил аргаар ашиглалт явуулдаг.

“Эрээний нүүрсний ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл”-ийг 2008 онд боловсруулж батлагдсан ТЭЗҮ-ийн дагуу уулын ажлыг явуулж байна. Тус ордын хойд хэсэг дэх өгөршөөгүй нүүрс бодитой/В/ зэргээр 241.8 мянган тн, өгөршсөн нүүрс боломжтой/С/ зэргээр 124.7 мянган тн, өмнөд хэсгийн өгөршөөгүй нүүрс боломжтой зэргээр 185.5 мянган тн батлагдсан нөөцтэй болохыг хайгуулын ажлаар тогтоожээ.

Эрээний нүүрсний уурхай нь жилд 50.0 мян.тн нүүрс олборлох хүчин чадлаар 10 жил ашиглана.

Уурхайн ажиллах горим: “Илчит металл” ХХК-ийн Эрээний нүүрсний уурхай нь ажиллах хүчний хувьд мэргэшсэн, тогтворжсон 36 ажилчидтай. 1 ээлжийн ажлын горимоор ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цагаар долоо хоногт 5 өдөр ажилладаг.

Ил уурхай нь дулааны улиралд хөрс хуулалт, нүүрс олборлолтыг зэрэг явуулж, хүйтний улиралд зөвхөн нүүрс олборлолтын ажил хийнэ. Амралт, баяр ёслол, цаг агаарын саатал ба бусад нөлөөллийн өдрүүдийг тооцоод жилд 305 хоног ажилладаг.

Тус компани нь 2023 онд хөрөнгө оруулалт байхгүйн улмаас уурхайн олборлолт явуулаагүй бөгөөд нийгмийн хариуцлагын хүрээнд 2023 оны 11 сарын 01-ээс 11 сарын 21-ний өдөр хүртэл 20 хоногийн хугацаанд орон нутгийн бага орлоготой өрхүүдэд нүүрс нийлүүлж ажилласан.

“Илчит металл” ХХК нь 2021 онд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн нэмэлт тодотголыг “Хос нахиа” ХХК-иар боловсруулуулан БОАЖЯ-аар батлуулсан.

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Шаалийн хөндийн эвдэрсэн газрыг дүүргэн, хайргаар тэгшилсэн.

Тэрбум мод тарих ажлын хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газраас ирүүлэн 7/579 тоот албан бичигт заасан тухайн онд эвдрэлд орсон талбайг 1 га тутамд 1000 мод тарих хувилбарыг баримтлаж ажилласан.

Мөн тайлан онд 800 ш шинэс модыг тус тус тарьсан.

ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2023 онд хөрөнгө оруулалт байхгүйн улмаас уурхайн олборлолт явуулаагүй бөгөөд нийгмийн хариуцлагын хүрээнд 2023 оны 11 сарын 01-ээс 11 сарын 21-ний өдөр хүртэл 20 хоногийн хугацаанд орон нутгийн бага орлоготой өрхүүдэд нүүрс нийлүүлж ажилласан.

Тайлант онд уурхайн олборлолт 20 хоног хийгдсэн ба үлдсэн хугацаанд хөрөнгө оруулалт байхгүйн улмаас сул зогсолт хийсэн болно. Дээрх ажилласан хугацаа нь 11 сард тул уурхайн дотоод, гадаад замыг услах, тоосжилт дарах шаардлага гараагүй.

Уурхайд ашиглагдах машин техникүүдээс ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах зорилгоор агаар бохирдуулсны төлбөрийг төлж, шаардлагатай тохиолдолд техникийн үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийж ирсэн.


Тус онд уурхайн олборлолт хийгдээгүй тул шимт хөрс хуулаагүй, овоолго үүсгээгүй, ус ашиглах шаардлага гараагүй.

2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр Булган аймгийн БОГ-ын усны шинжилгээний лабораторид 55.0 мянган төгрөг шилжүүлсэн.

Мөн сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор авто пүүний орох, гарах хэсэгт цементэн хамгаалалт хийсэн.



Зураг 2. Авто пүүний 2 талыг цементлэсэн байдал
Ажилчдын байрны лагерын талбайн гэрэлтүүлгийг лед гэрлээр сольсон.



Зураг 3. Уурхайн көмпэд лед гэрэл суурилуулсан байдал
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал 1105.6 мянган төгрөг.

ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Ордын ашиглалтын явцад эвдэрсэн газрын гадарга, хэвлий, байгалийн унаган төрхөө алдсан газрыг булж тэгшлэх, аюулгүй болгох(нурах, гулсах г.м.), хэлбэржүүлэх, суваг шуудуу татаж хөрсний эвдрэл үүсэхээс хамгаалах, тэгшилж хэлбэржүүлсэн талбайг шимт хөрсөөр хучихад техникийн нөхөн сэргээлтийг хийдэг.

Түүнчлэн техникийн нөхөн сэргээлтээр хэлбэршүүлсэн талбайг шимт хөрсөөр хучиж, тэгшлэн булдаж, чийг хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлснээр техникийн нөхөн сэргээлтийн ажил дууссан гэж үзвэл биологийн нөхөн сэргээлтэд шилжүүлнэ.

2022 онд цар тахал шинэ корона вирусын халдварт өвчний улмаас уурхайн ажил явагдаагүй бөгөөд тус онд тушаасан нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг 2023 он руу шилжүүлсэн. Тус тайлант онд үндсэн үйл ажиллагаа эхлээгүй боловч 2023 онд хуулсан 12650м³ хөрсийг дотоод овоолгод дүүргэлт хийж техникийн нөхөн сэргээлт хийсэн.

Уурхайн эхний блокын ашиглалт дуусаагүй тул 2025 оноос биологийн нөхөн сэргээлт хийнэ.

Ногоон байгууламж

Тэрбум мод тарих ажлын хүрээнд АМГТГ-ын нүүрс судалгааны хэлтсийн даргын 7/579 тоот албан бичгээр ирсэн хувилбаруудын дагуу эвдрэлд орсон талбанй 1 га тутамд 1000 мод гэсэн хувилбарыг сонгож 2023 онд өнгөн хөрсөнд ойр илэрц хэсэгт /95*25м/ 0,23 га эвдрэлд орсон газартай хөрс хуулж дээрхи хувилбараар тооцон мод үржүүлэгчээс 80 тн ялгасан нүүрсээр солилцоо хийж 250ш мод авсан. Тус модыг уурхайн кемпийн хашааны 2 талд хуваан тарьсан.



Зураг 4. Уурхайн тосгонд мод тарьж буй байдал

ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2023 онд хөрөнгө оруулалт байхгүйн улмаас уурхайн үйл ажиллагаа явуулаагүй боловч дүйцүүлэн хамгааллын ажлыг Булган аймгийн ЗДТГ-тай зөвшилцөн гүйцэтгэсэн. Тус дүйцүүлэн хамгааллын ажлаар Сайхан сумын 4-р багийн нутагт малын голлох бэлчээр нутаг болох Шаалийн хөндий нэртэй газрын байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүссэн гүн цав, гуу бүхий хагарлыг нөхөн сэргээх ажилд 12 ажилтан, хүнд даацын 2 автомашин, түрэх ачих механизм оролцуулан 9.2 км зайтай газраас 385 шоо мерт хайрга, чулууг зөөвөрлөн ан, цавыг бөглөж 9310 м² буюу 0.93 га газрыг түрж тэгшилсэн байна.



Зураг 5. Нөхөн сэргээлт хийж буй байдал



Зураг 6. Нөхөн сэргээлт хийсний дараах байдал

Дэлгэрэнгүй тайланг хавсаргав.

Нийт зардал 5696.3 мянган төгрөг.

ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

MV-014228 тоот уурхайн тусгай зөвшөөрлийн талбайд малчин айл, өрх амьдардаггүй. Иймд 2023 онд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох ажил хийгдэхгүй.

ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Палеонтологийн судалгааг 2020 онд Стратиграфи-Палеонтологийн судалгааны төвөөр хийлгэсэн бөгөөд тусгай зөвшөөрлийн талбайгаас эртний амьтан ургамлын чулуужсан үлдэгдэл илрээгүй байна.

Мөн тайланд онд уурхайн ашиглалт явагдаагүй тул уурхайн талбайд нүдэнд ил харагдах түүх соёлын дурсгал илрээгүй болно.

ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тайлант 2023 онд байгалийн болзошгүй аюул осол/газар хөдлөлт, усны үер, салхи шуурга, аянга цахилгаан, гал түймэр, үйлдвэрлэлийн осол, халдварт өвчин тархах г.м/ гарч уурхайн үйл ажиллагаа болон ажилчдын эрүүл мэндэд хохирол учруулаагүй болно.

Мөн тайлант онд тэсэлгээний ажил хийгдээгүй, тэмрэх материалын агуулахад тэсрэх материал 0 үлдэгдэлтэй. Тэсрэх материалын агуулахын сунгалтыг хийлгэсэн. Тэсрэх материалын харуулын байранд камер суурилуулсан.

Уурхайн ерөнхий газардуулга зүүн ууланд хийж байршуулсан.

Нийт төсөв 425.0 мянган төгрөг.

НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

MV-014228 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Эрээний нүүрсний уурхайн талбайд хаягдал дугуй болон хаягдал төмрийн цэг байгуулсан ба хаягдлыг төвлөрүүлсэн. Тус цэгийг байгуулснаар хаягдал дахин боловсруулах үйлдвэрт тушаах боломжтой болж байна.

Нийт зардал 165.0 мянган төгрөг.

ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

MV-014228 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Эрээний нүүрсний уурхайн үйлдвэрлэлийн үндсэн хөрс хуулалт, нүүрс олборлолт хийгдээгүй.

АРАВ. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

2023 онд хөрөнгө оруулалт байхгүйн улмаас уурхайн олборлолт явуулаагүй бөгөөд нийгмийн хариуцлагын хүрээнд 2023 оны 11 сарын 01-ээс 11 сарын 21-ний өдөр хүртэл 20 хоногийн хугацаанд орон нутгийн бага орлоготой өрхүүдэд нүүрс нийлүүлж ажилласан.

АРВАННЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Эрээний нүүрсний уурхайд ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд 1 удаа хамруулсан. Мөн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах зорилготой мэдээллийн самбар, анхааруулгыг хийж байршуулсан.

Нийт зардал 585.0 мянган төгрөг.

**АРВАНХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ
ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

“Илчит металл” ХХК 2023 онд уурхайн олборлолт үйл ажиллагаа явуулаагүй боловч тус онд хийж, хэрэгжүүлсэн ажлын талаар Булган аймгийн Сайхан сумын Байгаль орчны ХУБ болон Сайхан сумын иргэдийн төлөөлөлд тус тус танилцуулж, тайлагнасан.

Нийт зардал 35.0 мянган төгрөг

ДҮГНЭЛТ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ЗАРЦУУЛСАН НИЙТ ТӨСӨВ

Хүснэгт 2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн төсөв

| № | Зардлын ангилал | Зардал, мян.төг |
|----------------------------|---|-----------------|
| 1 | Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ | 1105.6 |
| 2 | Техникийн нөхөн сэргээлт | 685.5 |
| 3 | Биологийн нөхөн сэргээлт | - |
| 4 | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ | 5696.3 |
| 5 | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ | - |
| 6 | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | - |
| 7 | Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө | 910.5 |
| 8 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 165.0 |
| 9 | Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр | - |
| 10 | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | 585.0 |
| 11 | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах | 35.0 |
| Нийт төсөв, мян.төг | | 9182.4 |

“Илчит металл” ХХК-ийн MV-014228 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Эрээний нүүрсний уурхайн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд нийт **9182.4** мянган төгрөг зарцуулсан байна.

ИЛЧИТ МЕТАЛЛ ХХКОМПАНИЙ 2023 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДҮЙЦҮҮЛЭН
ХАМГААЛАХ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ДҮГНЭЛТ

2023.06.10

Дугаар 23/01

Сайхан сум

Илчит металл ХХКомпани Сайхан сумын 4-р багын нутагт орших "Шаалын хөндий" нэртэй газарын байгалийн гамшгаас үүссэн хүн, техник, мал осолдох өндөр эрсдэлтэй гүн гав, цав тогтож цаашид аюултай болж газрын эвдрэлд илүү өртөх магадлалтай байгаа газрыг нөхөн сэргээх зорилгоор Сумын ЗДТГазар, компани хамтран зөвшилцөж дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөөнд нь тусгасан.

Илчит металл ХХКомпани өөрийн 12 ажилтан зөөврийн хүнд даацын хоёр өөрөө буулгагч автомашин, түрэх, ачих зориулалттай механизм оролцуулан сумын засаг дарга, ЗДТГазрын дарга, Сумын Байгаль Орчны улсын байцаагч нарын заавар, зөвлөлгөөн, хяналтанд нөхөн сэргээлтийн ажлыг доорх байдлаар гүйцэтгэжээ.

- Илчит металл ХХКомпани 2023 оны 5-р сарын 19-нөөс 22-ны хугацаанд тус сумын 4-р багын нутаг болох иргэдийн зорчих хөдөлгөөн ихтэй малын голлох билчээр бүхий "Шаалын хөндий" нэртэй газрын байгалийн давтагдашгүй хүчин зүйлийн улмаас үүсэж эвдэрсэн гүн гав, гуу, хагаралыг нөхөн сэргээх ажилд 12 ажилтан хүнд даацын хоёр машин, түрэх ачих механизм оролцуулан
102°076'11.12 E 48°066'53.15 N 102°075'66.72 E 48°066'59.8 N
102°076'32.24 E 48°066'78.14 N 102°076'81.45 E 48°066'71.4 N
солбилцол бүхий талбайд хийж гүйцэтгэсэн байна.
Энэ хугацаанд зөвшөөрөгдсөн 9.6 км-д орших газраас 385 шоо метр хайрга чулууг автаар зөөвөрлөн ан, цав, гүн гавийг бөглөж 9310 м² буюу 0.93 га газрыг түрж тэгшлэн нөхөн сэргээж авар осолгүй болголоо.
- Энэ ажилд уурхайн ажилтан нараас гадна Авто зам ашиглалтын автогредер болон сумын удирдлагууд, малчид иргэдээс 8 хүн оролцон дэм тус болсон.
- Дүйцүүлэн хамгаалах ажлын нөхөн сэргээх ажилд Илчит металл Компани 5696.3 м² д.төгрөгийн шууд зардал зарцуулсан байна.

Илчит металл ХХКомпаний дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг шаардлага хангасан гэж дүгнэн сумын 4-р баг болон малчдын хяналтанд шилжүүллээ.

Холбогдох материалыг ард хавсаргав.

Дүгнэлт гаргасан:

Сайхан сумын ЗДТГ-ын дарга

Байгаль Орчны улсын байцаагч

Илчит металл ХХК-ны

Гүйцэтгэх захирал




**Илчит металл ХХКомпаний 2023 оны Байгаль Орчны Менежментийн төлөвлөгөөний
дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд эвдэрч, эзэнгүй орхигдсон талбайг
нөхөн сэргээсэн ажлын гүйцэтгэл**

2023.09.28

| № | Хийгдсэн ажлын төрөл | Хэмжих нэгж | Гүйцэтгэлийн | | Ажлын хэмжээ | Нийт зарцуулсан зардал /төг/ | Тайлбар |
|-------------------|---|-------------|--------------|--------------|--------------------------------------|------------------------------|--|
| | | | Ажил эхлэсэн | Ажил дууссан | | | |
| 1 | Эрээний нүүрсний уурхайгаас "Шаалын хөндий" нэртэй эвдэрсэн газарт техник, механизм хүргэсэн зардал | 4 техник | V.19 | V.19 | 31 км.т | 887.2 | Шатахуун, тос, цалин /элэгдэл тооцоогүй/ |
| 2 | Эвдэрсэн газрын дүүргэлтэнд зориулан зөвшөөрөгдсөн газраас хайрга, чулуу ачиж, тээвэрлэж зөөсөн | м3 | V.20 | V.22 | 21 рейс 385м3 | 2245.5 | Ачилт, зөөврийн шатахуун, цалин /элэгдэл тооцоогүй/ |
| 3 | Эвдэрсэн газарт буулгасан хайрга, чулууг түрж тэгшилэн нягтруулж хөрсжүүлсэн | м2/га | V.21 | V.23 | (38*245) 9310м2 буюу 0.93га | 1643.1 | Түрэлт, тэгшилэлтийн шатахуун, цалин /элэгдэл тооцоогүй/ |
| 4 | Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн талбайгаас уурхай хүргэсэн техник, механизмын зөөврийн зардал | 4 техник | V.22 | V.22 | 31 км.т | 695.3 | Шатахуун тос, цалин |
| 5 | Бусад зардал | Ажиллагсад | V.19 | V.22 | Үйлчилгээ хангамж | 225.2 | Хоол унд, тээвэр, ХХ-ын зардал |
| Нийт зардалын дүн | | | | | | 5696.3 | |

Гүйцэтгэл гаргасан
Гүйцэтгэх захирал
Ахлах нябо



Б. Ганболд
Б. Гантөмөр

Хянасан:
Сайхан сумын БОЯНЫ улсын байцаагч
Ц.Ичин хорлоо



1. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ХАЯГИЙН ХЭСЭГ

| | | | | | | | |
|---------------------------------|--------------------|---|---|-----|---|---|---|
| Регистрийн дугаар | 2 | 7 | 8 | 4 | 0 | 4 | 1 |
| Аж ахуйн нэгж, байгууллагын нэр | "Илчит металл" ХХК | | | | | | |
| Байршил | Нэр | | | Код | | | |
| Аймаг, нийслэл | Булган | | | | | | |
| Сум дүүрэг | Сайхан | | | | | | |

2. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

| | | | | | | | | |
|-------------------------------|-----------------|---|---|---|---|---|---|---|
| Тусгай зөвшөөрлийн дугаар | М | V | 0 | 1 | 4 | 2 | 2 | 8 |
| Тусгай зөвшөөрлийн талбай, га | 65,59 га | | | | | | | |
| Ашиглалт эхэлсэн он сар өдөр | 2 | 0 | 0 | 8 | | | | |
| Ашигт малтмалын төрөл | Нүүрсний уурхай | | | | | | | |
| Ашиглалтын төрөл | Ил уурхай | | | | | | | |

3. УУЛ УУРХАЙН АШИГЛАЛТ

| Үзүүлэлт | МД | Хэмжих нэгж | Нийт | 2023 |
|---|----|-------------|------------------------------|-------------|
| | | | | Тайлант онд |
| А | Б | В | 1 | 2 |
| Олборлолтод өртсөн нийт талбай | 1 | - | 0.23 | 0.23 |
| Ашигласан талбай | 2 | га | 0.23 | 0.23 |
| | 3 | мян.м³ | 12.6 | 12.6 |
| Хаягдал чулуулгийн овоолго | 4 | га | Дотоод овоолго дүүргэлт 0.23 | 0.23 |
| | 5 | мян.м³ | 12.6 дотоод овоолго | 12.6 |
| Хөрсний овоолго | 6 | га | 0.0 | 0.00 |
| | 7 | мян.м³ | 0.0 | 0.0 |
| Уул уурхайн дагалдах дэд бүтцийн нөлөөнд эвдэрсэн газар | 8 | га | 0.0 | - |
| Бусад | 9 | га | - | - |

4. УУЛ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ

| Үзүүлэлт | МД | Хэмжих нэгж | Нийт | Техникийн | Биологийн |
|---|----|-------------|---------|-----------|-----------|
| | | | | 2 | 3 |
| А | Б | В | 1 | 2 | 3 |
| Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээнд заасан нөхөн сэргээлт хийх нийт талбайн хэмжээ | 10 | га | 3.0 | 3.0 | - |
| | 11 | мян.м³ | 2075.0 | 2075.0 | 0.00 |
| Тайлант онд нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн талбай | 12 | га | 1.1 | 1.1 | 0.0 |
| | 13 | мян.м³ | 495.0 | 495.0 | 0.0 |
| Нөхөн сэргээлт нийт хийсэн талбай мөр14≥мөр16, мөр15≥мөр17 | 14 | га | 13.64 | 13.64 | - |
| | 15 | мян.м³ | 3976.9 | 3976.9 | - |
| Тайлант онд нөхөн сэргээлт хийсэн талбай | 16 | га | 0.23 | 0.23 | - |
| | 17 | мян.м³ | 12.6 | 12.6 | - |
| Нөхөн сэргээлт хийхэд зарцуулсан зардал мөр18≥мөр19, | 18 | мян.төг | 45685.5 | 45685.5 | - |
| | 19 | мян.төг | 685.5 | 685.5 | - |
| Байршуулсан нөхөн сэргээлтийн баталгааны нийт мөнгөн хөрөнгө, мөр20≥мөр21, | 20 | мян.төг | 0.0 | 14855.0 | - |
| | 21 | мян.төг | 0.0 | 2075.0 | - |
| Байгаль хамгаалахад зарцуулсан нийт зардал мөр18≥мөр19, | 22 | мян.төг | 47164.0 | 47164.0 | - |
| | 23 | мян.төг | 9182.9 | 9182.9 | - |

ТАМГА

Захирал/Эзэн  Н.Батсуурь /

Нягтлан бодогч  / Б.Гантөмөр /



**Илчит металл ХХК-ийн 2023 оны үйл ажиллагааны
товч танилцуулга**

2023.11.06

Илчит металл ХХК нь 2003 онд уул уурхайн ашиглалт, нүүрс олборлолт хийх үйл ажиллагааны чиглэлээр үүсгэн байгуулагдсан.

Компани 2003 оны 9-р сараас эхлэн Буллаг аймгийн Сайхан сумын 4-р багийн нутагт байрлах Эрээний чулуун нүүрсний ордыг ашиглах зорилгоор нэмэлт хайгуулаар нөөцийг тогтоон 8766А, MV-014228 тус тус тоот ашигт малтмал олборлох ашиглалтын тусгай зөвшөөрлийн дагуу 2003 оны 10-р сарын 01-нээс /8766А/ 2008 оны 9-р сарын 30-наас /MV-014228/-ийг 30 жилийн хугацаатай АМГТХЭГ-аас олгогдсон аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлөөр ил уурхайн аргаар хөрс хуулж, нүүрс олборлон Булган, Архангай аймгийн төв тэдгээрийн сумдын иргэд, аж ахуйн нэгж байгуулага, сургууль, цэцэрлэг, эмнэлэг болон Эрдэнэт хотын аж ахуйн нэгж айл өрхүүдийг нүүрсээр хангах үйл ажиллагаа явуулж ирсэн билээ.

Ашиглалтын жилүүдийн хугацаанд буюу 2003 оноос 2020 оны 8-р сар хүртэл 2824800 шоо метр хөрс хуулж 524000 тонн нүүрс олборлон Булган, Архангай болон Хөвсгөлийн зарим сум, Эрдэнэт хотын зарим аж ахуйн нэгж иргэдийн түлшний хэрэгцээнд нийлүүлсэн байна.

Тус ордын нүүрс нь хатуу тод гялгар өнгөтэй хөө тортоггүй үнслэг 14%, дэгдэмхий 41%, хүхэр 0.8%, дулаан гаргах чадвар 5400-6800 хүртэл к.кlor-тай өндөр чанарын чулуун нүүрс юм.

Үндсэн үйл ажиллагаанаас гадна өөрийн туслах аж ахуй, дагалдах үйл ажиллагааг хөгжүүлэх, цар хүрээг өргөжүүлэхээр өөрийн 278.6 сая төгрөгийн хөрөнгөөр эрчим хүчний 10квт-ийн агаарын шугам дэд өртөөг барьж байгуулан эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй болсон.

Уурхайчидын лагерт үүрэн холбооны Скайтель, Юнителийн суурин станцтай, ажилчдын 10 байр, 288 м² талбай бүхий спорт заал, халуун ус, саун, хоолны нэгдсэн байр байгуулан уурхайчдын ая тухтай ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлсэн.

Уурхайчдын хүнсний хангамжийг хангах зорилгоор 450 гаруй бог мал, 100 гаруй бод мал үржүүлэн өвөлжөө, хаваржааны иж бүрэн хашаа барьж ашиглалтанд оруулсан.

Хөрс хуулалт, олборлолтын ажилд HYUNDAI-1200 маркийн 6.3 куб.метрийн багтаамжтай шанага бүхий экскаватор 60 тонн даацтай сүүлийн үеийн хүнд даацын зөөврийн автомашин, өрөм комперссор, бульдозер, ковш зэрэг уул тээврийн хүнд машин, механизмууд ажиллаж байна.

Монгол улсад “Ковид19” цар тахал дэгдсэнээс шалтгаалан хоёр жил зургаан сар гаруй хугацаанд үйлдвэрлэл “0” зогсолтонд орсноос эргэлтийн нөөц хөрөнгө барагдаж цар тахлын өвчлөл намдаж энгийн байдалд шилжсэн үеэс өнөөг хүртэл үйлдвэрлэлээ сэргээх зорилгоор хөрөнгө оруулагч болон хамтран ажиллагч хайж санал тавиж хэд хэдэн түнштэй ерөнхий тохиролцоо хийсэн боловч цаг хугацаа алдаж улам хүнд байдалд орсоор байна.

2023 онд үйлдвэрлэл явуулахаар оны эхэнд уулын ажлын төлөвлөгөө, Байгаль орчны мөн оны менежментийн төлөвлөгөө, боловсруулан батлуулж тэсрэх материалын байнгын харуулын гэрээ, дизель түлш нийлүүлэх гэрээ, сэлбэг болон бүх төрлийн тослох материалын гэрээ, техник болон ажиллагсдын даатгалын мөн татвар, төлбөр зэрэг бичиг баримтыг бүрэн хангасан.

Үйлдвэрлэл “Ковид19” цар тахлаас шалтгаалан 2 жил 6 сар гаруй хугацаанд “0” зогсолттой байснаас мөнгөн хөрөнгө дуусаж компани түүнийг дагаад уурхайчид хүнд байдалтай явж ирсэн ба одоо ч үргэлжилсээр байна.

Компани өөрийн бүхий л боломж байгаа нөөц, чадварыг ашиглан санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэхээр оролдлого хийсэн боловч эргэлтийн хөрөнгө бүрдэхгүйгээс тэр бүр үр дүнд хүрсэнгүй.

Гэвч үйлдвэрлэлийн илүүдэлтэй хөрөнгө техникүүдийг зарж борлуулах замаар тухайлбал уурхайн лагерьт ажлын байр, сууц барихаар нөөцөлж байсан 125 м³ төрөл бүрийн банз, 165 м³ балк болон хүнсний бод, бог мал, контейнер сууц, хово автосамосвал, суудлын машин, шланз, ковш нөөцлөгдсөн зарим нэг сэлбэг, барилгын материал зэрэг хөрөнгөө борлуулснаас гадна нүүрсний складын талбайн ул болон үндсэн мөргөцгийн нурлын доорхи нүүрс цэвэрлэж авах, нүүрсний давхаргын өнгөн хөрсөнд ойр байсан илэрц хэсэгт суналын дагуу 95м, уналын дагуу 25м газар байгаа мөнгөнийхээ хэмжээнд хязгаарлагдан 0.23 га газар хөрс хуулж нүүрс олборлосон зэргээр санхүүгийн нөөц бэлтгэснээр 2023 оны 11-р сарын 15-ны байдлаар 12650 шоо метр нурлын хөрс болон гарш хэсгийн хөрс хуулж 3645 тонн нүүрс өссөн дүнгээр олборлон тодорхой хэмжээний орлого олж олон сараар бүтэн олгож чадаагүй уурхайчид, ажилчдынхаа цалин, татвар даатгал, НДШ-ийн зарим хэсгийг олгож төлж шилжүүлээ.

Байдал хэдий хүнд байгаа ч хүлээсэн үүргээ хийсэн ажлынхаа хэмжээнд тулгуурлан боломжийн хирээр гүйцэтгэлээ.

2023 онд Сайхан сумын засаг дарга, ЗДТГ-тай зөвшилцөн өгсөн хуваарийн дагуу дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас эвдрэлд орсон зам, орчны жалга, гуу, гүн хагарал цаашид эвдрэл ихсэж малчид, зорчигч болон мал түүний бэлчээрийн талбайд онцгой аюултай орчин бий болж болзошгүй “Шаалын хөндий” нэртэй газарт 1га талбайн нөхөн сэргээлт хийх ажлыг 5-р сарын 19-нөөс 22-ний хугацаанд өөрийн уул тээврийн хүнд машин техникийг зөөвөрлөн хүргэж 385 шоо метр хайрга, чулуу зөөвөрлөн эвдрэлд орсон ан, цав, гүн гавийг бөглөж нийт 9310м² буюу 0.93га газарт нөхөн сэргээлт хийж энэ ажилд 5696.3 мянган төгрөгийн зардал гаргаж цаашид эвдрэлийг зогсоож осол аваарь гаргахааргүй болголоо.

Мөн 5-р сард АМГТГ-ын нүүрс судалгааны хэлтсийн даргын 2022.01.31 өдрийн 7/579 тоот “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд өгсөн хувилбаруудын тухайн онд эвдрэлд орсон талбайн 1га тутамд 1000 мод гэсэн хувибарыг сонгож 2023 онд өнгөн хөрсөнд ойр илэрц хэсэгт /95м*25м/ 0.23 га эвдрэлд орсон газартай хөрс хуулж дээрхи хувилбараар тооцон мод үржүүлэгчээс 80 тонн ялгасан нүүрсээр солилцоо хийж 250ш мод авч уурхайн лагерь орчны ойжуулах талбайд тарьсны гадна Сайхан сумын 5-р багийн иргэн Банзрагчийн Орхон голын дэнжид тариалсан чацарганы ойгоос 100 чацарганы суулгац худалдан авч лагерьийн ойжуулах талбайг баяжуулав.

2023 оны 11-р сарын 10-наас 23-ны хооронд Сайхан сумын нэн ядуу болон өндөр настан, иргэдэд жил бүрийн тогтсон заншлын дагуу 85 өрхөд ялгаж ангилсан нүүрс өрх бүрт 1-ээс 2тн-ыг үнэгүй ба бүтэн үнээр олголоо.

Мөн энэ хугацаанд Булган, Архангай, Хөвсгөл аймгуудын сумдад өвлийн бэлтгэлд нь зориулан зохих хэмжээний нүүрсээр хангалаа.

Цаашид аль болох хөрөнгө оруулалтыг түргэтгэх үйлдвэрлэлээ сэргээх, хэвийн байдалд оруулахад хамт олон уурхайчин бидний чармайлт юу юунаас илүү зорилт болгон ажиллаж байна.

ТАЙЛАН БИЧСЭН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.БАТСУУРЬ